



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 09 өдөр

Дугаар А/398

Чингис хот

Батламж бичиг хийлгэхэд зориулж
зхөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.6-ийн "а", Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.20, Монгол улсын Ерөнхий сайдын 2020 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн "25 дугаар захирамж, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2020 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн А/268 дугаартай тушаал, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар шинэчлэн батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол улсын Ерөнхийлөгч короновируст халдвар(COVЮ 19)-тай тэмцэж буй Бүгд Найрамдах Хятад Ард Улсын ард түмэнд найрсаг хөршийн хувиар сэтгэлийн дэмжлэг үзүүлэх зорилгоор Монголын ард түмнийг төлөөлөн 30 мянган (толгой) хонь хандивлахаар шийдвэрлэсний дагуу Хэнтий аймгаас 8 мянган толгой хонь бэлтгэх ажилд оролцсон малчдад батламж бичиг гардуулахад зориулж 1440000 /нэг сая дөрвөн зуун дөчин мянган/ төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн урьдчилан тооцох боломжгүй нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д, батламж хийлгэх бэлтгэлийг хангаж, зохион байгуулах ажлыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

001010453